

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2020 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

№ 40/01

Улаанбаатар хот

**Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.8 дахь заалтыг тус тус удирдлага болгон Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн 2019 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлан талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Компанийн ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2020 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

№ 20/02

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.11 дэх заалт, 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинээр сонгогдох даргад даалгасугай.



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
2020 оны 3 сарын 28-ны өдрийн ээлжит хурлын
___ тоот шийдвэрийн ХАВСРАЛТ No1



**ЛЭНДМН ББСБ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТӨСӨВ**

No	Зардлын зүйл	Гишүүний тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
1	Цалин, урамшуулал	9	11,925,000	12	143,100,000
1.1	ТУЗ-ийн дарга	1	1,500,000	12	18,000,000
1.2	ТУЗ-ийн хорооны дарга	3	1,200,000	12	43,200,000
1.3	ТУЗ-ийн гишүүн	5	1,000,000	12	60,000,000
1.4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	500,000	12	6,000,000
2	Хурал болон бусад зардал				10,280,000
	НИЙТ ТӨСӨВ				153,380,000

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2020 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

№ 40/03

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 31.2.2, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд дараахь агуулгатай өөрчлөлт оруулсугай.

№	Өөрчлөлт оруулахаас өмнөх	Өөрчлөлт оруулсны дараах
1.1	8.4.12.ТУЗ-өөс боловсруулсан компанийн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэн батлах;	8.4.12.ТУЗ-өөс боловсруулсан компанийн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэн батлах;
1.2	8.5.7.хувьцааг нэгтгэх буюу хуваах;	8.5.7.хувьцааг нэгтгэх буюу хуваах;
1.3	8.11.Компанийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.	8.11.Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.
1.4	9.6.11.компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;	9.6.11.компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах, хөрөнгө оруулалт хийх замаар компани үүсгэн байгуулах, хууль болон нийтээр дагаж мөрдөх журамд заасан хүрээнд бусад хуулийн этгээдийн хувь эзэмшлийг худалдан авах, Компанийг төлөөлж үүсгэн байгуулагч, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг томилох, бүрэн эрхийг нь тодорхойлох;
1.5	9.7.ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.	9.7.ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хүрээнд хариуцуулан гүйцэтгүүлж болно.
1.6	14.6.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;	14.6.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд улируулан эсхүл шинээр сонгуулахаар нэр дэвшүүлэх;
1.7	19.2.Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтгэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж	19.2.Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн хуралд оролцсон саналын эрхтэй, сонирхлын зөрчилгүй гишүүд 100 хувь санал нэгтгэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай

	чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.	шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.
1.8	20.6. Сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:	20.6. Компани нь дараах тохиолдолд Сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:
1.9	22.2.Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.	22.2.Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу эргүүлэн худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
1.10	22.3.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болно.	22.3.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болно.
1.11	4.2 Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:	4.2.8. Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах
1.12	4.2 Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд:	4.2.9. Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх

2. Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДАРГА
О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2020 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

№ 20/04

Улаанбаатар хот

**Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг
нэмэгдүүлэх саналыг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 5.2.1, 5.2.2 дахь заалт, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын 3 дугаар бүлгийн 3.3, 3.5 дахь заалт, 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 5,000,000,000 (таван тэрбум) хүртэл төгрөгийн хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх саналыг баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэмжээнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Хоёрдогч өглөгийн нөхцөлийг тогтоох, гэрээ байгуулах болон эдгээртэй холбогдон үүсэх бусад асуудлаар Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгож шийдвэрлэсүгэй.



О.БОЛДБААТАР

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2020 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

№ 20/05

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
зарим гишүүдийг улируулан сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, 77 дугаар зүйлийн 77.1 болон 77.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)–ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дараах гишүүдийн бүрэн эрхийн хугацааг 1 (нэг) жилээр сунгаж, улируулан сонгосугай.
 - 1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн:
 - 1.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэн овогтой Болдбаатар
 - 1.1.2. Монгол Улсын иргэн Володьяа овогтой Баярсайхан
 - 1.1.3. Монгол Улсын иргэн Баянжаргал овогтой Дэлгэржаргал
 - 1.1.4. Монгол Улсын иргэн Нармандах овогтой Цэвэгмид
 - 1.1.5. Монгол Улсын иргэн Сэнгээ овогтой Энх-Амгалан
 - 1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хараат бус гишүүн:
 - 1.2.1. Монгол Улсын иргэн Сүрэнхүү овогтой Боргил
 - 1.2.2. Монгол Улсын иргэн Жигдэн овогтой Жаргалсүрэн
 - 1.2.3. Монгол Улсын иргэн Чинбат овогтой Номин
2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг улируулан сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн болон Хараат бус гишүүдэд үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д даалгасугай.



**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2020 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

№ 20/06

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, 77 дугаар зүйлийн 77.1 болон 77.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.4.7 дахь заалт, 2020 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүнээр Цэвэгжав овогтой Одмааг сонгосугай.
2. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 1 (нэг) жил буюу дараа жилийн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл үргэлжлэхийг дурдсугай.
3. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад Компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Ердийн гишүүн Цэвэгжав овогтой Одмаа-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Мөнхцэцэг)-д даалгасугай.



О.БОЛДБААТАР